Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын шүдний гэмтлийн яаралтай тусламжийн талаарх мэдлэг, хандлагыг судалсан дүн

Н.Цэцэгхэн[1], Г.Батболд[1], А.Мөнхдөл[2], Б.Энх-Орчлон[1]*

[1]АШУҮИС, НАСС, Нүүр амны мэс заслын тэнхим*
[2]"Ач" Анагаах Ухааны Их Сургууль
Цахим шуудан: cdd20e004@gt.mnums.edu.mn, Утас: 99195875

Түлхүүр үг:

Шүдний хугарал
Шүдний булгарал
Шүдний мултрал
Анхны тусламж
Боловсрол

Товч утга:

Үндэслэл: Шүдний гэмтэл нь өндөр тархалттай, хувь хүн төдийгүй гэр бүлийн амьдралын чанарт тодорхой нөлөө үзүүлдэг тул нийгмийн бүх давхаргад нөлөөлж буй нийгмийн эрүүл мэндийн томоохон асуудал юм. Шүдний гэмтлийн 71-92% нь 19 нас хүрэхээс өмнө тохиолддог. Манай оронд 6-18 насны хүүхдүүд ЕБС-д суралцдаг. Эдгээр насны хүүхдүүд шүдний гэмтэлд өртөх өндөр эрсдэлтэй бүлгийг төлөөлдөг. Сургууль дээрх шүдний гэмтэл нь хичээлийн цагаар ихэвчлэн спортоор хичээллэх мөн бусад биеийн тамирын дасгал хийх үед гарсан осол гэмтлийн улмаас шүд, буйл, амны хөндийн бусад бүтцэд гэмтэл учруулахыг хэлнэ. Хүүхдүүдийн сургуульд зарцуулдаг цагийг харгалзан шүдний гэмтлийн тохиолдолтой таарах магадлал ихэнхдээ багш нарын хувьд өндөр байдаг. ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх судалгааны ажлууд дэлхийн олон улсад хийгдсэн байна. Тэдгээр судалгааны ихэнх нь багш нарын шүдний гэмтлийн талаарх хандлага, мэдлэг нь дутмаг байна гэж дүгнэсэн байна. Манай орны хувьд энэ сэдвээр судалгаа хийгдээгүй байгаа нь бидний судалгааны ажлын үндэслэл болсон. **Зорилго:** ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэг, шүдний гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх талаарх хандлагыг үнэлэхэд оршино. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшны загвараар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд ЕБС-д бүтэн цагаар ажилладаг ба нэг жилээс дээш ажлын туршлагатай багш нарыг хамруулсан. Судалгааг Google Form онлайн хэрэгслийг ашиглан багш нарын цахим шуудан руу илгээсэн. Багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг үнэлэх асуулт нь хамгийн ихдээ 14 оноо авах боломжтой. **Үр дүн:** Цахим судалгааны асуумжийг нийт 2821 багш бөглөсөн бөгөөд багш нарын дундаж нас 36.7±9 жил, багшилж буй дундаж хугацаа 13.0±9 жил байсан. Багш нарын шүдний гэмтлийн мэдлэгийн дундаж оноо 5.32±2.1 байсан. Шүдний гэмтлийн мэдлэгийн оноо өндөр байх нь багшийн нас (p=0.001), ажилласан жилийн туршлагатай статистик ач холбогдол бүхий ялгаатай байгаа нь тодорхойлогдлоо (p=0.001). **Дүгнэлт:** ЕБС-ын багш нарын дунд хүүхдэд тохиолдож болох шүдний гэмтлийн талаарх мэдлэг хангалтгүй байна. Багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэг өндөр байх нь гэмтлийн үед тусламж үзүүлэх эерэг хандлагатай байна.

Үндэслэл: Шүдний гэмтэл нь өндөр тархалттай, хувь хүн төдийгүй гэр бүлийн амьдралын чанарт тодорхой нөлөө үзүүлдэг тул нийгмийн бүх давхаргад нөлөөлж буй нийгмийн эрүүл мэндийн томоохон асуудал юм.[1] Шүдний гэмтлийн 71%-92% нь 19 нас хүрэхээс өмнө тохиолддог.[2] Манай улсад хүүхдүүд 6 наснаас эхлэн бага сургуульд элсэн сурч байгаа бол 18 насанд хүүхдүүд ахлах сургуулиа төгсөж байна. Эдгээр насны

хүүхдүүд шүдний гэмтэлд өртөх өндөр эрсдэлтэй бүлгийг төлөөлдөг. Хүүхдийн сурч тоглох орчин хязгаарлагдмал хаалттай, сургууль дээрээ ихэнх цагыг өнгөрүүлдэг, биеийн тамирын идэвхтэй хөдөлгөөнтэй, үе тэнгийнхний хоорондын зөрчил болон эцэг эхийн хараа хяналт багассан, багш нарын хяналт нэгэн зэрэг олон тооны сурагчдад тавих чадвар хомс зэрэг хэд хэдэн хүчин зүйлс шүдний гэмтэл үүсэхэд нөлөөлдөг байна.[3–7] Сургууль дээрх шүдний гэмтэл нь хичээлийн цагаар ихэвчлэн спортоор хичээллэх мөн бусад биеийн тамирын дасгал хийх үед гарсан осол гэмтлийн улмаас шүд, буйл, амны хөндийн бусад бүтцэд гэмтэл учруулахыг хэлдэг.[8,9]

Хүүхдүүдийн сургуульд зарцуулдаг цагыг харгалзан шүдний гэмтлийн тохиолдолтой ихэнхдээ таарах магадлал багш нарын хувьд өндөр байдаг.[3,10–12] Тиймээс гэмтсэн хүүхдийг зөв эмчлэхийн тулд тусгай ур чадвар, мэдлэг шаардлагатай байдаг. Шүдний гэмтлийн үед болон дараа нь үүсдэг өвдөлт болон зовуурриас гадна гэмтсэн шүдний зөөлц, холбоос гэмтэх нь шүдний урт хугацааны тавиланг алдагдуулж хүнд гэмтэл авсан тохиолдолд шүдээ алдахад хүргэдэг.[13] Гэмтсэн шүдний ойролцоогоор гуравны нэгд зөөлцийн үхжил, халдвар, үрэвсэлт шимэгдэл, бүрэн хэлбэржээгүй шүдний сурвалж саатах зэрэг байнгын үр дагавар үүсдэг нь тогтоогдсон.[14] Эдгээр хүндрэлүүд нь шүдний олон төрлийн эмчилгээг шаарддаг бөгөөд энэ нь өвчтөнд таагүй мэдрэмж төрүүлэхээс гадна хүүхэд болон эцэг эхийн аль алинаас цаг хугацаа, зардал их шаарддаг.[15] Тиймээс зохих үр дүнтэй яаралтай тусламж үзүүлэх нь чухал юм.

Гэмтсэн шүдний урт хугацааны тавилан нь осолд өртсөн үеэс эмчилгээ хүртэлх хугацаа, ослын газарт тусламж үзүүлсэн хүний арга хэмжээний чанар, шүдний эмнэлэгт шүдний эмчийн сонгосон эмчилгээ зэргээс хамаардаг болохыг судлаачид онцолсон байна.[16]

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх судалгааны ажлууд дэлхийн олон улсад хийгдсэн байна. Тэдгээр судалгааны ихэнх нь багш нарын шүдний гэмтлийн талаарх хандлага, мэдлэг нь дутмаг байна гэж дүгнэсэн байна.

Шүдний гэмтлийн талаар анхан шатны мэдлэгтэй болсноор багш нар сурагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, шүдний ослын үед зохих дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд тусалдаг. Иймээс сургуулийн багш нарт шүдний гэмтлийн янз бүрийн хувилбаруудад яаралтай тусламжийн арга хэмжээг хэрхэн зөв зохицуулах талаар мэдээлэх, сургах нь чухал юм.

Манай орны хувьд энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажил ховор байгаа нь энэхүү судалгааны үндэслэл боллоо.

Зорилго: ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэг, шүдний гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх талаарх хандлагыг үнэлэх.

Зорилт:

1. ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламжийн мэдлэг, хандлагыг тодорхойлох.
2. Шүдний гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламжийн мэдлэг, хандлагын хоорондын хамаарлыг тодорхойлох
3. Шүдний гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламжийн мэдлэгт нөлөөлөх хүчин зүйлүүдийн хамаарлыг судлах.

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшны загвараар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд ЕБС-д бүтэн цагаар ажилладаг ба нэг жилээс дээш ажлын туршлагатай багш нарыг хамруулсан.

Судалгааны асуумжийг шүдний гэмтлийн талаарх ижил төстэй судалгааг хийсэн судлаачдын асуумжуудаас сонгон боловсруулсан. Сонгогдсон Англи хэл дээрх асуултуудыг хоёр судлаач нэгнээсээ хамааралгүйгээр Монгол хэл рүү орчуулсан. Зөрөөтэй орчуулсан үг, өгүүлбэр дээр судалгааны зөвлөхтэй хамт ярилцан эцсийн шийдвэрт хүрсэн. Судалгааны асуумжийн сүүлийн Монгол хэл дээрх хувилбарыг мэргэжлийн орчуулагчаар Англи хэл рүү орчуулж эх сурвалжтай харьцуулсан. Судалгааг Google Form онлайн хэрэгслийг ашиглан багш нарын цахим шуудан руу илгээсэн.

Судалгааны асуумжийг ЕБС-ийн багш нарт илгээхээс өмнө урьдчилсан туршилт судалгааг АШУҮИС-ийн харьяа ахлах сургууль болон төрийн бус өмчийн Арвис сургуулийн нийт 20 багш нарын дунд хийсэн бөгөөд багш нар судалгааны асуумжуудыг унших ойлгоход хүндрэлгүй байсан (Cronbach's coefficient alpha 0.967). Урьдчилсан туршилт судалгаанд хамрагдсан сургуулиуд дараагийн шатны буюу энэхүү судалгаанд хамрагдаагүй.

Судалгаанд хамрагдсан ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг үнэлэх нэг болон олон хариултгай нийт 14 асуулт боловсруулсан. Зөв харилт бүрд нэг оноо, харин буруу хариулт бүрд 0 оноогоор үнэлсэн бөгөөд авч болох дээд оноо 14 байна. Статистик боловсруулалтыг SPSS 26.00 программ ашиглан one-way ANOVA болон регрессийн шинжилгээ хийсэн.

Судалгааны ажлыг явуулах зөвшөөрлийг АШУҮИС, Био-Ангаахын Ёс зүйн Салбар Хорооны 2022 оны 3-р сарын 25 өдрийн хурлаар хэлэлцүүлж (2022/3-03) зөвшөөрөл авсан.


Үр дүн: Судалгааны асуумжийг Монгол улсын хэмжээнд Улаанбаатар, Төвийн бүс, Баруун бүс, Зүүн бүс, Хангайн бүсүүдийн төрийн өмчийн болон хувийн ЕБС-иудын нийт 2941 багш бөглөсөн. Эдгээр багш нараас 210 багш нэг жилээс бага ажлын туршлагатай байсан тул судалгаанаас хассан бөгөөд нийт 2821 багш нар судалгаанд хамрагдсан. Эдгээр багш нараас эмэгтэй багш 2433 (86%) байсан ба багш нарын дундаж нас 36.7±9 жил, багшилж буй дундаж хугацаа 13.0±9 жил байсан. Судалгаанд хамрагдсан багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг үнэлэхэд 14 онооноос дундаж оноо 5.32±2.1 байсан. Судалгаанд хамрагдсан багш нарын 810 (28%) нь бага, 813 (29%) дунд, 1198 (42%) алхах ангид хичээл заадаг бөгөөд 1528 (54%)

байгалийн ухааны хичээлүүд, 1293 (46%) нийгмийн ухааны хичээл заадаг.Шүдний гэмтлийн мэдлэгийн оноо өндөр байх нь багшийн нас (p=0.001), ажилласан жилийн туршлагатай статистик ач холбогдол бүхий ялгаатай байсан (p=0.001). Мөн байгалийн шинжлэх ухааны хичээл заадаг багш нарын дундаж оноо нийгмийн шинжлэх ухааны хичээлийн багш нараас өндөр байгаа нь ажиглагдсан. Судалгаанд Улаанбаатар хотоос 645 (23%), Баруун бүс 663 (24%), зүүн бүс (16%), хангайн бүс 598 (21%), төвийн бүсээс 463 (16%) багш нар тус тус хамрагдсан бөгөөд төвийн болон зүүн бүсийн багш нарын мэдлэг бусад бүс нутгийн багш нараас өндөр байна (Хүснэгт 1).


Хүснэгт 1. ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг тодорхойлсон дүн

Үзүүлэлтүүд		Тоо n=(2821)	%	Мэдлэгийн оноо (mean+SD)	P утга
Хүйс	Эмэгтэй	2433	86	5.34±2.13	0.181
	Эрэгтэй	388	14	5.18±2.34	
Нас (бүлгээр)	20-29	675	24	4.98±2.09	*0.001*
	30-39	1114	39	5.20±2.15	
	40-49	769	27	5.59±2.19	
	50-59	240	9	5.84±2.15	
	60 болон дээш	23	1	6.26±1.78	
Багшилсан туршлага жилээр	1-5	751	26	4.99±2.09	*0.001*
	6-10	529	19	5.12±2.10	
	11-15	507	18	5.38±2.22	
	16 болон дээш	1034	36	5.63±2.18	
Багшилж буй анги	Бага (1-4)	810	28	5.32±2.14	0.995
	Дунд (5-8)	813	29	5.31±2.20	
	Ахлах (9-12)	1198	42	5.31±2.16	
Хичээлийн төрөл	Байгалийн шинжлэх ухаан	1528	54	5.40±2.21	*0.022*
	Нийгмийн шинжлэх ухаан	1293	46	5.22±2.10	
Боловсролын зэрэг	Бакалавр	2001	70	5.28±2.15	0.160
	Магистр	816	29	5.41±2.97	
	Доктор	4	1	4.00±2.16	
Сургуулийн төрөл	Төрийн өмчийн	2769	98	5.31±2.16	0.065
	Хувийн	52	2	5.87±2.25	
Сургуулийн байршил	Улаанбаатар	645	23	5.20±2.11	*0.028*
	Баруун бүс	663	24	5.16±2.11	
	Зүүн бүс	452	16	5.46±2.22	
	Хангайн бүс	598	21	5.37±2.16	
	Төвийн бүс	463	16	5.49±2.24	
Шүдний гэмтлийн талаарх өөрийн мэдлэгийн үнэлгээ	Муу	607	21	5.00±2.11	*0.001*
	Дунд	1714	60	5.31±2.17	
	Сайн	57	2	5.46±2.39	
	Маш сайн	432	16	5.73±2.10	

Нийт 944 (26%) багш ажлын байран дээр буюу сургуулийн орчинд сурагчдын дунд шүдний гэмтэл тохиолдож байсан гэж хариулсан. Сурагчдын дунд сургуулийн орчинд тохиолдсон гэмтэл зонхилон тохиолдсон байршлыг судлахад 36.2% нь тоглоомын талбайд, 32.5% нь анги тамхимд, 18.4% биеийн тамир зааланд, 12.8% нь коридорт гэмтсэн болох нь тус тус тодорхойлогдлоо (Зураг 1).



Зураг 1. Сургуулийн орчинд шүдний гэмтэл тохиолдсон байршлыг судалсан дүн



Зураг 2. Сургуулийн орчинд шүдний гэмтэл үүссэн шалтгааныг судалсан дүн

Бид сургуулийн орчинд шүдний гэмтэл үүссэн шалтгааныг судлахад 24.3% нь унах, 19.6% нь тоглох, 7.4% нь гүйх, 4.2% зодоон, 44.5% нь бусад шалтгааны улмаас гэмтсэн болох нь тус тус тодорхойлогдлоо (Зураг 2).

Багш нар ‘’Та сурагчдад тохиолдох шүдний гэмтэл нь багшийн зүгээс яаралтай анхаарал хандуулах шаардлагатай гэж бодож байна уу?’’ хэмээх асуултанд санал нэг байна гэж хариулсан багш 1494 (52.9%) байсан. Багшийн шүдний гэмтлийн талаарх мэдлэг болон хандлагын хамаарлыг судлахад багшийн мэдлэгийн дундаж оноо өндөр байх нь эерэг хандлагатай статистик ач холбогдол бүхий хамааралтай байгаа нь ажиглагдсан (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх хандлагыг тодорхойлсон дүн

Үзүүлэлтүүд	Тоо	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95%-ийн итгэх интервал	
					Доод хязгаар	Дээд хязгаар
Та сурагчдад тохиолдох шүдний гэмтэл нь багшийн зүгээс яаралтай анхаарал хандуулах шаардлагатай гэж бодож байна уу?						
Тийм, Санал нэг байна	**1494**	**5.91**	2.123	0.055	5.81	6.02
Үгүй, Санал нийлэхгүй байна	176	5.11	2.007	0.151	4.81	5.41
Хэлж мэдэхгүй байна	1151	4.57	2.009	0.059	4.46	4.69
Нийт	2821	5.32	2.168	0.041	5.24	5.40

Тайлбар: *P=0.001 (One-way ANOVA)*

Хэлцэмж: Tewari N (2020) нарын судалгаанд сургуулийн багш нарын дундах шүдний гэмтлийн талаарх мэдлэг болон түүнээс урьдчилан сэргийлэх, яаралтай тусламж үзүүлэх талаар судалгаа Саудын Араб болон Энэтхэг зэрэг орнуудад харьцангуй их хийгдсэн байна.[3] Иймд манай улс төдийгүй бусад бүс нутгуудын мэдлэг, хандлага, туршлагыг цаашид судлах зөвлөмжийн дагуу багш, сургуульд сургалтын нэг хэсэг болгон заах арга хэмжээг авч үзэх шаардлагатай байна.

Судлаач Ivanda S (2021) нарын судалгаанд багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг үнэлэхэд 14 онооноос дунджаар 6.5±2.5 оноо авсан байгаа нь тодорхойлогдсон бол бидний судалгаагаар 14 онооноос дунджаар 5.32±2.1 оноо авсан нь эдгээр судлаачдын үр дүнтэй ойролцоо буюу мэдлэг бага байгааг харуулж байна гэж үзэж байна.[2]

Alsadhan SA (2018) Kong H (2012) нар судалгаандаа багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийг хүйсээр харьцуулан судлахад статистик ач холбогдолгүй байсан нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.[6,17] Харин Pithon M (2014) нарын судалгаанд өөр дүн гарсан бөгөөд эмэгтэй багш нар эрэгтэй багш нартай харьцуулахад мэдлэгийн түвшин өндөр байсан нь бидний судалгааны үр дүнгээс ялгаатай байна.[18]

Шүдний гэмтлийн мэдлэгийн оноонд нас ба ажилласан жилийн туршлага чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаач Tzimpoulas N (2020), Alsadhan S (2018), Ivanda S (2021), Antunes L (2016) нар тэмдэглэсэн ба бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.[2,6,11,19] Тодруулбал нас болон ажилсан жилийн туршлага нь хоорондоо шууд холбоотой бөгөөд илүү олон жил ажилласан ахмад багш нар илүү сайн мэдлэгтэй байж болох нэг шалтгаан нь багшлах ажлынхаа туршид илүү олон шүдээ гэмтээсэн хүүхэдтэй таарсан байж болох юм.

Зүүн болон төвийн бүсийн багш нарын дундаж оноо өндөр байсан бөгөөд үүний шалгаан нь тус бүс нутагт ажиллаж буй багш нарын ажилласан жил бусад бүс нутгаас их байсантай холбоотой байна.

Орон нутгийн дийлэнх сурагчид хичээлийн улиралд дотуур байранд байрлаж байгаа тул багш нарын шүдний гэмтлийн мэдлэгийг нэмэгдүүлэх, анхны тусламж үзүүлэх чадварыг олгох шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. ЕБС-ийн багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийн оноо (5.32±2.1) хангалтгүй байгаа хэдий ч шүдний гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламжийн хандлага эерэг байгаа нь ажиглагдаж байна.
2. Багш нарын шүдний гэмтлийн талаарх мэдлэгийн оноо өндөр байх нь гэмтлийн үед тусламж үзүүлэх эерэг хандлагатай хамааралтай байна.
3. Багшийн ажлын туршлага нэмэгдэх дусам шүдний гэмтлийн талаарх мэдлэгийн оноо нэмэгдэж байна.

Ном зүй:

1. *Petti S, Glendor U, Andersson L. World traumatic dental injury prevalence and incidence, a meta-analysis—One billion living people have had traumatic dental injuries. Dental Traumatology. 2018;34(2):71-86. doi:10.1111/edt.12389*
2. *Ivanda S, Gavic L, Galic T, Tadin A. School teachers' knowledge and experience about emergency management of traumatic dental injuries: A questionnaire-based online cross-sectional survey. Dental Traumatology. 2021;37(4):589-600. doi:10.1111/edt.12669*
3. *Tewari N, Goel S, Rahul M, et al. Global status of knowledge for prevention and emergency management of traumatic dental injuries among school teachers: A systematic review and meta-analysis. Dental Traumatology. 2020;36(6):568-583. doi:10.1111/edt.12579*
4. *Marcano-Caldera M, Mejía-Cardona JL, Parra Sanchez JH, et al. Knowledge about emergency dental trauma management among school teachers in Colombia: A baseline study to develop an education strategy. Dental Traumatology. 2018;34(3):164-174. doi:10.1111/edt.12393*
5. *Awad MA, Alhammadi E, Malalla M, et al. Assessment of Elementary School Teachers' Level of Knowledge and Attitude regarding Traumatic Dental Injuries in the United Arab Emirates. Int J Dent. 2017;2017. doi:10.1155/2017/1025324*
6. *Alsadhan SA, Alsayari NF, Abuabat MF. Teachers' knowledge concerning dental trauma and its management in primary schools in Riyadh, Saudi Arabia. Int Dent J. 2018;68(5):306-313. doi:10.1111/idj.12385*
7. *Feldens EG, Feldens CA, Kramer PF, da Silva KG, Munari CC, Brei VA. Understanding school teacher's knowledge regarding dental trauma: A basis for future interventions. Dental Traumatology. 2010;26(2):158-163. doi:10.1111/j.1600-9657.2009.00863.x*
8. *Tzanetakis GN, Tzimpoulas N, Markou M, Papanakou SI, Gizani S, Georgopoulou M. Evaluating the knowledge level, attitudes, and therapeutic approaches of Greek dentists for traumatic dental injuries. Dental Traumatology. 2021;37(2):177-187. doi:10.1111/edt.12623*
9. *Lam R. Epidemiology and outcomes of traumatic dental injuries: A review of the literature. Aust Dent J. 2016;61:4-20. doi:10.1111/adj.12395*
10. *Sae-Lim V, Peng Lim L. Singapore pre-school teachers. Dental Traumatology. 2001;17:71-76.*
11. *Tzimpoulas N, Markou M, Zioutis V, Tzanetakis GN. A questionnaire-based survey for the evaluation of the knowledge level of primary school teachers on first-aid management of traumatic dental injuries in Athens, Greece. Dental Traumatology. 2020;36(1):41-50. doi:10.1111/edt.12503*
12. *Al-Obaida M. Knowledge and management of traumatic dental injuries in a group of Saudi primary schools teachers. Dental Traumatology. 2010;26(4):338-341. doi:10.1111/j.1600-9657.2010.00894.x*
13. *Levin L, Day PF, Hicks L, et al. International Association of Dental Traumatology guidelines for the management of traumatic dental injuries: General introduction. Dental Traumatology. 2020;36(4):309-313. doi:10.1111/edt.12574*
14. *McIntyre JD, Lee JY, Trope M, Vann WF. Elementary school staff knowledge about dental injuries. Dental Traumatology. 2008;24(3):289-298. doi:10.1111/j.1600-9657.2007.00542.x*
15. *Mori GG, Turcio KHL, Borro VPB, Mariusso ÂM. Evaluation of the knowledge of tooth avulsion of school professionals from Adamantina, São Paulo, Brazil. Dental Traumatology. 2007;23(1):2-5. doi:10.1111/j.1600-9657.2005.00391.x*
16. *Andersson L, Andreasen JO, Day P, et al. Guidelines for the management of traumatic dental injuries: 2. avulsion of permanent teeth. Pediatr Dent. 2017;39(6):412-419. doi:10.1111/j.1600-9657.2012.01125.x*
17. *Kong H, Young C, Young C, Wong KY, Cheung LK. Emergency Management of Dental Trauma: Knowledge of Hong Kong Primary and Secondary School Teachers Private Practice. Vol 18.; 2012. www.hkmj.org*
18. *Pithon MM, dos Santos RL, Magalhães PHB, da Coqueiro RS. Brazilian primary school teachers' knowledge about immediate management of dental trauma. Dental Press J Orthod. 2014;19(5):110-115. doi:10.1590/2176-9451.19.5.110-115.oar*
19. *Antunes LAA, Rodrigues AS, Martins AM do C, Cardoso ES, Homsi N, Antunes LS. Traumatic dental injury in permanent teeth: knowledge and management in a group of Brazilian school teachers. Dental Traumatology. 2016;32(4):269-273. doi:10.1111/edt.12249*

School teacher's knowledge and attitude about emergency management of traumatic dental injuries

Tsetsegkhen N[1], Batbold G[1], Munkhdul A[2], Enkh-Orchlon B[1]*

[1]Department of Oral and maxillofacial surgery, School of dentistry, MNUMS*
[2]"Ach" medical university
E-mail: cdd20e004@gt.mnums.edu.mn, Tel: +976-99195875

Background: Dental trauma is one of the critical (71-92%) oral health problems in childhood and adolescence that can affect an individual's quality of life. Teachers may witness a dental injury on many occasions, and they are likely to be involved at the site of an accident. Hence, they may have some knowledge about dental injury and should be capable of managing prompt and correct emergency treatment at the accident site.
Aim: Assess to knowledge of Mongolian school teachers and their attitude with regard to emergency first aid management of traumatic dental injuries occurring in schools.
Materials and Methods: A questionnaire based cross sectional online survey was conducted to determine knowledge and attitude about traumatic dental injuries among 2821 full time working elementary and high school teachers. The inclusion criteria were full time employment at the time of data collection with at least 1 year of teaching experience. The Student *t* test or one-way ANOVA was used to evaluate the obtained data. The level of significance was set at $p \leq 0.05$. The study approved by the Research Ethics Committee of MNUMS (2022/3-03).
Results: The overall mean level of teachers' knowledge regarding emergency management of dental trauma was 5.32±2.1 points, out of a maximum possible score of 14. There were significant differences in better knowledge teachers age (p=0.001) and teachers working experience (p=0.001).
Conclusions:

1. The knowledge score f school's teachers about dental injuries (5.32±2.1) is insufficient, although the first aid attitude towards dental injuries is positive.
2. A higher teacher knowledge score about dental trauma is associated with a positive attitude toward trauma care
3. As the teacher's work experience increases, the knowledge score about dental injuries increases.

Keywords: Avulsion, Fractures, Luxations, First aid, Education